



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/03

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөтөнч овогт Батмөнхийн Гал нь Шивээговь сумын 1-р баг, 3, 4-р байрны хойд талд байрлах “Автомашины гараж”-ийн зориулалттай 21м<sup>2</sup> газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Боржигин овогт Төмөртоогоогийн Ариунаад Шивээговь сумын 1-р баг, 3, 4-р байрны хойд талд байрлах 21м<sup>2</sup> газрыг “Автомашины гараж”-ийн зориулалтаар эзэмших эрхийг 5-н жилийн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Т.Ариунаа)-т үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Т.Ариунаатай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Баярмагнай)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/27 дугаар захирамжийн 3 дахь бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА